БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

Б.ОДБАЯР

АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН ПРОГРАММ ХАНГАМЖИЙН ЛИЦЕНЗИЙН СУНГАЛТ БОЛОН ИНЖЕНЕР ТЕХНИКИЙН АЖИЛЧДЫГ МЭРГЭШҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2025 оны 12 сарын 26 Дугаар: 2607050366

1	**Зорилго**	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл, инженерийн тооцоо, төлөвлөлт, хөдөлгөөний загварчлал болон зам судалгааны ажлын гүйцэтгэл, чанар, үр ашиг, тооцооллын нарийвчлал, мэдээллийн урсгалын зохион байгуулалтыг сайжруулах зорилгоор байгууллагад ашиглаж буй мэргэжлийн программ хангамжийн лицензийг сунган баталгаажуулахын зэрэгцээ инженер, техникийн ажилчдын ур чадварыг шинэчилсэн стандарт, олон улсад ашиглагдаж буй программ хангамж болон аргачлалд нийцүүлэн мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулах.
2	**Үндэслэл**	**1. Эрх зүйн үндэслэл** - Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; - Төсвийн тухай хууль; - Авто замын тухай хууль; - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль; - Төрийн болон Албаны нуцын тухай хууль; - Кибер аюулгүй байдлын тухай хууль; - Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль - Бусад холбогдох хууль тогтоомжууд; **2. Тогтоол шийдвэр, бодлогын баримт бичиг** - Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/133 дугаар тогтоол; - Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1848 дугаар захирамж;
3	**Хамрах хүрээ**	Нийслэлийн Замын хөгжлийн газрын хэрэгжүүлж буй үйл ажиллагааны хүрээнд хамаарна
4	**Гүйцэтгэгч байгууллага**	Энэ чиглэлийн программ хангамж нийлүүлэх болон сургалт зохион байгуулж байсан туршлага бүхий хуулийн этгээд байх бөгөөд олон улсын стандартыг нэвтрүүлж, ёс зүйг дагаж мөрддөг байх шаардлагатай.
5	**Программ хангамж**	Дараах төрлийн программ хангамжуудыг 1 жил /12 сар/-ийн эрхтэйгээр нийлүүлэх /суурилуулах төхөөрөмжийн тоо/: 1. ROMDAS systems-ийн сунгалт - 1 төхөөрөмж 2. IndorCAD Road-ий сунгалт - 5 төхөөрөмж 3. Microsoft Office 365 E5 /эсхүл түүнтэй дүйцэх/ - 55 төхөөрөмж 4. Road Estimator

		/эсхүл түүнтэй дүйцэх/ - 48 төхөөрөмж 5. ArcGIS Online Professional (formerly Standard) User Type Annual Subscription /эсхүл түүнтэй дүйцэх/ - 2 төхөөрөмж 6. ArcGIS Online Professional Plus (formerly Standard) User Type Annual Subscription /эсхүл түүнтэй дүйцэх/ - 2 төхөөрөмж 7. ArcGIS Online Creator User Type Annual Subscription /эсхүл түүнтэй дүйцэх/ - 2 төхөөрөмж Программ хангамжийн албан ёсны баталгаа болон бусад холбогдох баримт бичгийн бүрдлийг хангах. Программ хангамжийн гарын авлага, бичлэг болон бусад багшгүйгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх.
6	**Программ хангамжийн сургалт**	Нийслэлийн Замын хөгжлийн газрын мэргэжилтнүүдийг холбогдох программын үйлдвэрлэгч байгууллагын албан ёсны сургалтад хамруулах.
7	**Мэргэшүүлэх сургалт**	Дараах төрлийн сургалтад хамруулах /хамрагдах мэргэжилтний тоо/: 1. Авто зам, гүүрийн дадлагажсан инженерийн зэрэг олгох сургалт – 7 мэргэжилтэн 2. Авто зам, гүүрийн мэргэшсэн инженерийн зэрэг олгох, сунгах сургалт - 19 мэргэжилтэн 3. Авто зам, гүүрийн төсөвчний анхан шатны сургалт - 22 мэргэжилтэн 4. Авто зам, гүүрийн мэргэшсэн төсөвчний зэрэг олгох, сунгах сургалт - 8 мэргэжилтэн 5. Авто зам, гүүрийн хяналтын инженерийн итгэмжлэх олгох, сунгах сургалт - 7 мэргэжилтэн
8	**Бусад**	• Нийлүүлж буй программ хангамж болон сургалтад холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ажиллах. • Нийлүүлж буй программ хангамж нь албан ёсны лицензтэй, хууль бус хуулбар бус байх ба программ хангамжийн лицензийг үйлдвэрлэгч байгууллагын баталгаа, ашиглагдаж байгаагүйг нотлох баримтын хамт хүлээлгэн өгөх. • Лицензийн дуусах хугацаа тодорхой тусгагдсан байх • Upgrade, patch, security update хийх боломжтой • Файл солилцоо, экспорт/импорт (DWG, DXF, SHP, IFC, CSV гэх мэт) • Монгол Улсад ашиглагдаж буй стандарттай (MNS, AASHTO, EN, ISO) нийцэх • Windows 10/11 орчинд бүрэн ажиллах • Лицензийн хугацаа дутуу, хүчин төгөлдөр бус тохиолдолд нийлүүлэгч бүрэн хариуцна. • Лиценз, лиценз сунгалттай холбогдох баталгааг 1 жил /12 сар/ хугацаатай хариуцна. • Лицензийн эхлэх хугацаа нь хүлээлгэн өгсөн өдрөөс эхлэх.

		• Нийлүүлэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн хүлээлгэн өгнө. - Лицензийн гэрчилгээ - Ашиглалтын гарын авлага - Сургалтын тайлан • Захиалагч нь лиценз идэвхэжсэн эсэх, сургалт бүрэн хийгдсэн эсэхийг шалган хүлээн авна.
9	**Ажлын хугацаа**	Захиалагч болон нийлүүлэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд заасан хугацааг үндэслэл болгоно.

Хянасан:

Нийслэлийн Замын хөгжлийн газрын

Бодлого төлөвлөлтийн хэлтсийн

Даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч:.....М.Ичинхорлоо

Боловсруулсан:

Нийслэлийн Замын хөгжлийн газрын

Бодлого төлөвлөлтийн хэлтсийн

Зураг төсөл хариуцсан инженер:.....С.Билэгбаяр